

24. Бурхан минь, Төв Азид олон аавууд ажил хийхээр гадны орныг зорьж, ээжүүд нь хүүхдүүдээ асран ганцаар үлдэж байгаа ч үүнээс болж олон гэр бүлүүд салахгүй байгаасай хэмээн залбирч байна. (Малахи 2:16)

25. Эзэн минь, Хойд Африкт бие махбодийн болон сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, гэр бүлүүдэд хамгаалалт болон эдгэрэлийг Та авчраач. (Дуулал 10:17-18)

26. Аав аа, хар тамхинд донтсоны улмаас биеэ үнэлэлэх байдалд орсон Израилийн эмэгтэйчүүдийг эдгээж, сэргээч. (Сургаалт үгс 24:11-12)

27. Эзэн минь, бид Тунисийн эмэгтэйчүүдийн шударга ёс болон тэдний эрхийн төлөө залбирч байна. Тус нутгийн эмэгтэйчүүд амьдралын бүхий л салбарт эрх тэгш, шударга байх болтугай. (Мика 6:8)

28. Бурхан минь, Алжир дахь эмэгтэйчүүдэд хөдөлмөр эрхлэх болон боловсрол эзэмших боломжийг нэмэгдүүлж өгөх болтугай. Тэд хүсэл мөрөөдлөө биелүүлэхийн тулд нийгэмдээ эерэг нөлөө үзүүлэх болтугай. (Сургаалт үгс 18:15)

29. Аав аа, Өмнөд Казахстаны итгэгч эмэгтэйчүүдийн төрөл төрөгсдийг Та өөртөө дуудаач. Тэд жинхэнэ Бурханд итгэж, Есүсээс авралыг олох болтугай. (Үйлс 2:39)

30. Эзэн минь ээ, Ойрхи Дорнодоос Хойд Кипрт цагаачлан ирж буй эмэгтэй оюутнуудын хамгаалагч Та байгаарай. Эмэгтэйчүүдийг хязгаарласан соёлын хэм хэмжээнээс ангид байх анхны мэдрэмжийг мэдрэх бүр олон хүн Есүсээс жинхэнэ эрх чөлөөг олж авах болтугай. (Гал. 5:1)

31. Аав аа, Туркийн өнгөрсөн сонгуулийн үр дүнд гарсан хоёр намын хооронд энх тайвныг авчраач. Тэд хамтран ажиллахад суралцаасай гэж залбирч байна. (Ром. 12:16)

Монголын төлөө залбирах сэдвүүд

1. Монгол улсыг удирдаж байгаа засгийн газрын гишүүд шударгаар ард түмнээ хайрлаж, Бурханаас эмээхийн төлөө
2. Монгол улсын хууль тогтоомж шударгаар үйлчилж, Монгол улс эдийн засгийн хямралаас гарахын төлөө.
3. Хиймэл шүтээн шүтэж харанхуй дотор алхаж байгаа хүмүүс Бурханыг таньж мэдэн гэм нүгэлээсээ эргэж гэмшихийн төлөө
4. Монголын гэр бүлүүд Эзэнтэй хамт алхдаг байхын төлөө. Гэр бүлүүд дотор өсөж торниж байгаа хүүхдүүдэд эцэг эхийн нөлөө зөв байхын төлөө
5. Монгол эрчүүд архинд донтон, гэр бүлдээ үл хүндлүүлэх байдал их байна. Эзэн Монгол эрчүүдийг өөрчлөн, гэр бүлийнхээ тэргүүн байж, гэр бүлдээ хайрлагдсан хүндлэгдсэн аавууд байхын төлөө
6. Монголын залуу гэр бүлүүд маш их салж байна. Олон хүүхдүүд өнчирч байна. Тиймээс залуучууд сонголтоо зөв хийж, үх хүүхдээ өнчрүүлэхгүй байхын төлөө
7. Монгол чуулганууд сэргээгдэж, сайн мэдээ орон даяар тунхаглагдаж, улс орноороо Эзэн рүү хандан залбирдаг, Эзэнээс эмээдэг ард түмэн болохын төлөө

후원안내

국민은행 851-01-0003-724 북방선교방송

최초 입금 후 사무실로 연락 주시기 바랍니다



Найдвартай
эмэгтэйчүүд

Сар бүр гаргадаг "Найдвартай эмэгтэйчүүд" залбирлын хуанлиг 100 хэл дээр орчуулагдсан бөгөөд 65,000 гаруй хүн хамтдаа залбирч байна.



2023. 10.

**CAMINA бүс нутгийн эмэгтэйчүүдийн
төлөөх залбирал2**

2022 оны 7-р сард Туркийн зүүн өмнөд хэсэгт Курманжи "Найдвар доторх эмэгтэйчүүд" нэвтрүүлгийн анхны нэвтрүүлэг эхэлсэн билээ. Амьдралын янз бүрийн нөхцөл байдалд байгаа эмэгтэйчүүдэд хүрэх зорилготойгоор долоо хоногт хоёр удаа цацагдаж байна. Хүнд хэцүү нөхцөлд өөрсдийгөө зориулан үйлчилж буй "Найдвар доторх эмэгтэйчүүд" багийн төлөө залбирч өгнө үү.

TWR Korea 북방선교방송

서울특별시 관악구 양녕로 15, 월드빌딩 6층
전화 (02)886-5671 / 이메일 phkorea@twrk.or.kr

1. Эзэн минь, энэ жил Турк болон Сирийн газар хөдөлгөөн болоод хайртай хэн нэгнээ алдсан, ажилгүй, амьдрах орон байргүй болсон Христ итгэлт хүмүүсийн төлөө залбирч байна. Тэд бусаддаа гэрэл болох болтугай. (Матай 5:16)

2. Аав аа, Кабилигийн “Найдвар доторх эмэгтэйчүүд” хөтөлбөрөөр дамжуулан чуулганы хаалттай байдал хавчлагаас болон зовж, шаналж байгаа Хойд Африкийн эмэгтэйчүүд Сүнсний хоолоор хангагдах болтугай. (Иохан 15:4-5)

3. Эзэн минь ээ, бэлгийн мөлжлөгийн хохирогчдын төлөө төлөө Изайрльд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын ажилчдыг хамгаалаач, “Нуугдсан эрдэнэ” хөтөлбөрөөр дамжуулан хүрээгээ тэлэхэд нь тэдэнд Та туслаач. (2Тимот4:18)

4. Бурхан минь ээ, эх орондоо сурахад их сургуулийн төлбөр өндөр тул гадны орныг зорин боловсрол эзэмшихийн тулд явж байгаа Туркийн залуучуудыг Та хамгаалах болтугай. (2Самуел 22:3-4)

5. Хойд Африкт ядуурал нэмэгдэхийн хэрээр хүмүүст хүмүүнлэгийн болон сүнслэг хэрэгцээг хангахаар эрэн хайж байгаа манай TWR-ийн “Найдвар доторх эмэгтэйчүүдийн”-ийн багт мэргэн ухааныг өгөөрэй. Ядуу хүнд харамгүйгээр өгөгч хүн ЭЗЭНд зээлүүлж байгаа хэрэг. (Сургаалт үгс 19:17)

6. Тажикистанд нөхөртөө хаягдсан ээжүүдийг Эзэн Та халамжлаач. Тэдний олонхи нь хүүхдүүдээ гэжээхийн тулд хуванцар сав цуглуулан түүнийгээ зарж, амь зогоож байна. Засгийн газар нь эдгээр эмэгтэйчүүдэд туслах болтугай. (Дэд хууль 31:8)

7. Аав аа, Хойд Киприйн анхны жижиг бүлгээс сүнслэг байдлаараа өссөн олон жижиг бүлгүүдийг бий болгох болтугай. Ариун Сүнс ээ Та энэ залбиралын хөдөлгөөнийг удирдах болтугай. (Ром 8:26)

8. Өөрсдийн итгэл найдвар, амьдралын утга учир, үнэ цэнийн мэдрэмжээ алдсан маш олон хүн Хойд Африкт байна. Олон эмэгтэйчүүд өөрсдийн жинхэнэ зорилго, үнэ цэнийг Есүсээс олж авах болтугай! (Матай 6:33)

9. Бурхан минь, Саудын Арабын эмэгтэйчүүд өөрсдийн чадавхийг нэмэгдүүлэх тэгш боломжоор хангагдаасай гэж бид залбирч байна. Тэд Найдвар

доторх Эмэгтэйчүүд хөтөлбөрөөр дамжуулан Бурханаас хүч чадлыг олж авах болтугай. (Галат 3:28)

10. Аав аа, бид хүчирхийлэлд өртсөн Курд эмэгтэйчүүдийн төлөө залбирч байна. Тэд Христ дотор эдгээр болон тусламжийг олж авах болтугай. (Иеремиа 33:6)

11. Каракалпакистанд ид шидийг үйлдэгчид одоо ч байсаар байна. Эзэн минь, эдгээр мухар сүсэгт мөргөгчид Есүс Христ доторх аврал, эдгээрийг олох болтугай. (Үйлс 19:18–20)



12. Хойд Африкийн Амазиг бүс нутгийн эмэгтэйчүүдэд үйлчилж буй “Найвар доторх эмэгтэйчүүд баг”-уудын төлөө Бурхан минь, Таныг бид магтъя. Эмэгтэйчүүдэд амьдралдаа агуу сүнслэг ойлголтыг олж авахад нь туслахын зэрэгцээ сэтгэл санааны болон сүнслэг халамжийг үзүүлж байгаа тэдгээр багуудыг ерөөх болтугай. (Ром 12:1–2)

13. Киргиз дэх "Найдвар доторх эмэгтэйчүүд" хөтөлбөрүүд болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан Христэд итгэгч эмэгтэйчүүдийн итгэл бэхжиж, улмаар тэд үл итгэгч гэр бүлийн гишүүдийнхээ дунд сүнслэг гэрэл нь байх болтугай. (Ефес 5:8)

14. Бурхан минь, бид Курдын "Найдвар доторх эмэгтэйчүүд" хөтөлбөрийн сонсогчидтой уулздаг үйлчлэлийн багийн хүмүүсийн төлөө залбирч байна. Тэдэнд сайн мэдээг хэрхэн хуваалцаж, хэрхэн ярилцах мэргэн ухааныг өгөх болтугай. (Ром. 1:16)

15. Арабын “Найдвар доторх эмэгтэйчүүд”-н хөтөлбөрүүд нь эдийн засаг, улс төрийн хямралыг туулж буй Ливаны эмэгтэйчүүдийг урамшуулж, нийгэмдээ өөрчлөлтийг бий болгох төлөөлөгч болоход нь туслах болтугай. (Естер 4:14)

16. Туркменистан дахь гэр бүлүүдийн дундах хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөн, гэр бүл салалт зэрэг нь хүүхдүүдийг эцэг эхгүй өсөхөд хүргэж байна. Эзэн минь Та эдгээр гэр бүлүүдэд эв нэгдэл, амар тайвныг өгөх болтугай. (Дуулал 133:1)

17. Илүү их эрх чөлөө, эрхийн төлөөх тэмцэлд амь насаа эрсдэлд оруулсаар байгаа Иран дахь эмэгтэйчүүдийн төлөө бид залбирч байна. Бурхан минь, эдгээр зоригт эмэгтэйчүүдийг хамгаалж, шударга ёсны төлөөх тэдний хашхираанд Эзэн Та хариулаач. (Дуулал 121:7–8)

18. Эзэн минь, Араб хэл дээрх “Найдвар доторх эмэгтэйчүүд” хөтөлбөрийг сонсоод Палестин дахь амар тайвныг хайж, Бурхантай эвлэрэхийг хүсч буй эмэгтэйчүүд итгэл найдварыг олж авах болтугай. (Ром 5:11)

19. Узбекистанд хүчээр гэрлүүлж буй залуу охидын хамгаалагч нь Та байгаарай, Аав аа. (Иеремиа 1:8)

20. Хойд Кипр улсад гэр бүл салалтын түвшин өндөр байна. Эзэн минь, тэнд гэрлэсэн хосуудын дунд байдаг "бид ямар нэг зүйлээр холбогдоогүй" гэсэн сэтгэлгээг үгүйсгэж, тэд хоорондоо үнэнч байж, хувиа хичээхгүй байхад нь туслаарай. (Матай 19:6)

21. Эзэн минь, бид Курдын "Найдвар доторх эмэгтэйчүүд" хөтөлбөрийг орчуулах, контекст болгон бэлтгэхийн төлөө залбирч байна. Эдгээр нэвтрүүлэг сонсогчдын зүрх сэтгэлийг өөрчлөх болтугай. (Коллосой 3:16)

22. Бурхан минь, Узбекистаны олон муслым эмэгтэйчүүдийн зүрх сэтгэл амиа хорлолт, найдваргүй байдлын сүнснүүдэд эзэмдүүлсэн байна. Танаас итгэл найдварыг олж авахын тулд Та тэднийг чөлөөлөөч. (Иеремиа 29:11)

23. Тэнгэрлэг Аав минь, Бахрейний жендэрт суурилсан хүчирхийллийг Та зогсоогооч. Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийг эдгээж, тэднийг Та сэргээгээч. (Дуулал 147:3)